

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

МОНГОЛЫН ИНТЕРНЕТ РАДИОГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Цэвэлмаа*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: интернет радио, подкастинг, аудио скроблинг, конвергенц

Интернет сэтгүүл зүй нь уламжлалт ОНМХ-ийн бааз суурин дээр үүсэж бий болсон. “Асар богино хугацаанд манай мэдээллийн хэрэгслүүдийн тоо эрс өсөн нэмэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн шинэ хэв маяг олноор бий болж, тэдний дотоод төрөл хэлбэрүүд өргөжин баяжсан нь Монголын сэтгүүл зүйд урьд өмнө байгаагүй цоо шинэ үзэгдэл болсон¹ гэж сэтгүүл зүйн доктор, профессор М.Зулькафиль тэмдэглэжээ. Энэ цоо шинэ үзэгдлийн нэг нь мэдээж мэдээллийн технологитой холбоотой үүсэж, хөгжиж байгаа интернет сэтгүүл зүй юм. Мэдээллийн технологи нь зөвхөн программ хангамж, компьютер, интернетийн сүлжээ төдийгүй сонин сэтгүүлийн эх бэлтгэх, хэвлэлийн технологийн шинэчлэл, радио телевизийн дүрс дууг бичих эвлүүлэх, дамжуулах арга тоон технологид шилжсэн зэргийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм. Орчин үед ОНМХ-д юу нийтлэх, юу нэвтрүүлэхийг сэтгүүлч биш олон нийт тодорхойлдог болсныг судлаачид интернеттэй холбон тайлбарлаж байна. Интернет нь сэтгүүл

зүйд дараах шинэ өөрчлөлт нөлөөг үзүүлж, түүний үйл ажиллагаанд шинэ онцлог, давуу талыг олгох болов. Үүнд:

- Эргэх холбоотой
- Мэдээллийн дан төвлөрөл
- Эгшин зуурын холбоо
- Хэрэглээний тоон хэмжигдэхүүн
- Хөдөлгөөнт чанар
- Харилцаамж
- Хямд хэрэглээ

Доктор Б.Болд-Эрдэнэ “Интернет сэтгүүл зүйд мэдээллийг уламжлалт сэтгүүл зүйтэй адил зөвхөн агуулга, тэмдэгтийн талаас нь авч үзэх нь учир дутагдалтай бөгөөд “Хамт нийтлэгжил”, “хийбэр бичиглэл” зэрэг ойлголтоор дамжуулан эргэх холбоо мөн чанар бүхий орчин үеийн харилцаа холбооны даяарчлагдсан орон зайн харилцаа мэдээллийн орчин”² гэж үзжээ. Ийнхүү интернетийн давуу талыг ашиглан уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд цахим хувилбар, шууд эфир зэргийг гаргаснаар интернет сэтгүүл зүйн уншигч сонсогч үзэгчийг нэг дор нэгтгэж чадсан мэдээллийн гол эх сурвалж харилцааны шинэлэг хэрэгсэл болж байна.

Нэвтрүүлгийг дуу чимээний тусламжтайгаар агаарын долгион ашиглан хязгаарлагдмал бус тооны сонсогчдод мэдээлэл дамжуулдаг техник хэрэгслийг өргөн утгаар нь

радио гэж үздэг. Гэтэл интернетийн сүлжээ бий болсноор радио сонсогчдын хүрээгээ нэмэгдүүлэх шинэ орон зайг нээж өгсөн юм. Манай улсад 1999 онд FM-102,5 радио станц анх вэб хуудаатай болжээ. 2003 оноос “Инфо FM-102,5” (www.inforadio.mn) радио нэвтрүүлгээ интернетээр цацах болсон.

Интернетээр радио сонсох боломжтой болсноор дэлхийн шилдэг дуу хөгжим, мэдээ мэдээллийг сонсож, хэлний мэдлэгээ сайжруулах боломжтой болжээ³. Манай улсад өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 68 богино долгионы радиогоос интернетээр нэвтрүүлгээ цацагддаг нь цөөхөн. Интернет радиог дэлхийн хаана ч байсан интернетийн сүлжээнд холбогдсон компьютерын тусламжтайгаар хүлээн авч сонсох боллоо. 2002 онд Монголд интернетээр сонсох боломжтой хоёр радио байсан бол, 2018 он гэхэд интернетээр сонсох боломжтой радио 18 болж өссөн нь радиог интернетээр шууд сонсох (үзэх) технологи нэвтэрсэнтэй холбоотой. Харин хөдөө орон нутгийн нэг ч радио интернетийг ашигладаггүй болох нь ажиглагдлаа.

Интернетийн сүлжээ ашиглан нэвтрүүлгээ сонсогчдод хүргэдэг манай улсын радио станцууд:

1. FM-102.5 Монголын хамгийн ууган FM
2. Монголын үндэсний олон нийтийн радио
3. Элгэн нутаг радио FM-96.9 live
4. Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчилэн хийдийн дэргэдэх “Лавайн эгшиг” FM-97.5
5. Хөдөө орон нутагт 89.9, DDISH TV 3-р сувгаар сонсох боломжтой.
6. МҮОНР-ийн гуравдугаар суваг. P-3 FM-100.9

7. МҮОНР-ийн гадаадын сонсогчдод зориулан нэвтрүүлэг дамжуулдаг “Монголын дуу хоолой” радио станц.
8. Гэр бүлийн радио FM-104.5
9. MGLRadio.com 102.1

Манай улсын радио станцууд интернетийн сүлжээ ашиглан нэвтрүүлгээ хүлээн авагчдад дамжуулахдаа гурван хэлбэр ашиглаж байна. Нэгдүгээрт, радио станцууд интернетийн сүлжээнд өөрийн вэбсайт нээж, нэвтрүүлгээ дамжуулдаг. Ингэхдээ радиогийн вэбсайтад тухайн радиогийн түүх, бүтэц зохион байгуулалт, хамт олны танилцуулга, нэвтрүүлгийн тухай танилцуулга мэдээлэл, мөн зар сурталчилгаа байршуулсан байдаг. Мөн агаарын долгионоор дамжуулж байгаа радиогийн эфирийг шууд хүлээн авахаас, архивт хадгалагдсан хуучны нэвтрүүлгийг ч нөхөж сонсох боломжтой. Тухайлбал, МҮОНР-гийн нэгдүгээр суваг, “Монголын дуу хоолой” радио станц, “Элгэн нутаг” FM-96.9 зэргийг дурдаж болно. Хоёрдугаарт, интернетийн сүлжээнд гар утас, планшетаар холбогдсон хэрэглэгч радио сонсох аппликэйшн (app) ашиглан радиогийн нэвтрүүлгийг сонсох боломж нээгдсэн. Жишээ нь, FM-102,5 радиогийн нэвтрүүлгийг, мөн МҮОНР-ийн нэвтрүүлгийг гар утасны аппликэйшн ашиглан сонсох боломжтой. Гуравдугаарт, интернет дэх олон нийтийн сүлжээгээр дамжуулан радиогийн нэвтрүүлгийг сонсохоос гадна радиогийн студид суугаа нэвтрүүлэгч, хөтөлөгч, нэвтрүүлгийн зочдыг үзэх боломжтой. Тухайлбал, МҮОНР-гийн нэвтрүүлгийг фэйсбүүк сүлжээгээр үзэх-сонсож болно. Ийнхүү радиог зөвхөн сонсдог гэсэн уламжлалт ойлголт технологийн дэвшлийн ачаар өөрчлөгдсөн. Мөн Солонгос дахь

Монголчуудын мэдээллийн нэгдсэн вэбсайтаар нягт холбоотой ажилладаг MGLRadio.com FM-102.1 үүнд хамруулж болно. Энэ радио станцын “100 асуулт 100 хариулт”, “Ярилцлагын цаг”, “Сэтгэлд шингэсэн дуунууд”, “10 хором” радио сэтгүүл, “Зочин эмч” нэвтрүүлэг, MGLMUSIC нэвтрүүлэг, “Гэр бүл” нэвтрүүлэг, “Радио аялал” нэвтрүүлэг, “Радио ертөнц” нэвтрүүлэг, “Радио номын сан”, “Радио такси” нэвтрүүлэг, “Радио авто клиник”, “Радио амьтны ертөнц”, “ARI BEAUTY TIME” нэвтрүүлэг, “Түмний нэг” нэвтрүүлэг, MGL RADIO LIVE COVER нэвтрүүлэг, “Солонгос дууны цаг”, “Аудио зохиол” гээд олон нэвтрүүлгийг сонсохоос гадна сайтаар нь дамжуулан студийн байр байдлыг үзэх боломжтой.

Дуу хөгжим төдийгүй радиогийн нэвтрүүлэг сонсох боломж олгож байгаа өөр нэг вэбсайт бол Хуур.мн (www.xyyp.mn) юм. “Хүн хөгжим хоёрыг холбоно” уриатай энэ сайтад нэвтэрсэн хэрэглэгч Р-3 радио, Улаанбаатар 102.5, Гэр бүлийн радио, Элгэн нутаг, Лавайн эгшиг, Их монгол зэрэг радио станцын нэвтрүүлгийг сонсож болно.

Монголын радио станцууд нэвтрүүлгээ интернетээр дамжуулж байгаагаас гадна монголчуудад зориулан тусгай нэвтрүүлэг бэлтгэдэг гадаадын орны радио станцууд ч интернетийн сүлжээнд өөрийн орон зайгаа эзэлсэн байна. ОХУ-ын “Оросын дуу хоолой” радио станц (хуучин нэрээр) 2014 оны эцэс хүртэл монгол хэлээр нэвтрүүлэг бэлтгэж байхдаа интернетийн сүлжээнд нэвтрүүлгээ байршуулдаг байлаа. Харин 2015 оноос “Оросын дуу хоолой” радио станц бүтцийн өөрчлөлтөд хамрагдаж, монгол хэлээр нэвтрүүлэг бэлтгэдэг редакц нь татан буугдсан юм.

Хятадын олон улсын радиогоос монгол хэлээр бэлтгэдэг нэвтрүүлгийг уламжлалт богино долгион (MW), Улаанбаатар хотод хэт богино долгионоор (FM) дамжуулахаас гадна интернет сүлжээгээр www.mongol-cri.cn сайтаар цацагддаг. Богино долгионоор өдөрт 6 удаа буюу тус бүр 1 цагаар нийт 6 цагийн нэвтрүүлэг, хэт богино долгионоор өдөрт 8 удаа буюу тус бүр 2 цагаар нийт 16 цагийн нэвтрүүлэг явуулж байна. Хятадын олон улсын радиогийн монгол хэлний нэвтрүүлэг 2000, 2006, 2009 онд Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт хотод хэт богино долгионоор нэвтрүүлгээ шууд дамжуулж эхэлсэн. Хятадын олон улсын радио нь цаг үеийн мэдээ, мэдээлэл, хятад хэлний хичээл, хятад орны тухай тусгай нэвтрүүлгийг тогтмол бэлтгэдэг. Мөн интернетийн сүлжээнд вэбсайтаар тус радиогийн нэвтрүүлгийг сонсож болохоос гадна хятадын гар утасны Wechat аппликэйшнээр Хятадын олон улсын радиогийн нэвтрүүлгийг хүлээн авч сонсож болно.

Ийнхүү Хятадын олон улсын радио монгол хэлээр нэвтрүүлэг бэлтгэдэг нэвтрүүлэгтээ онцгой хүчин чармайлт гаргаж байгаа бол Австрали улс ч монгол хэлээр радио нэвтрүүлэгт явуулах асуудалд зохих хэмжээнд анхаарал хандуулж эхэлсэн байна. 2018 оны тавдугаар сарын 28-ны өдрөөс эхлэн Австралийн SBS радио монголчуудад зориулсан мэдээ мэдээлэл түгээх платформ үүсгэн нэвтрүүлж эхэлснээ албан ёсоор зарласан юм. Уг радиогоор Австрали улсад амьдарч буй монголчуудын туршлага болоод үндэсний ёс заншлаа тэмдэглэн уламжлахаас гадна улсынхаа түүхийг харилцан ярилцах зорилготой аж. Австралийн радиогийн монгол хэлээр бэлтгэдэг хөтөлбөрөөр шинээр ирсэн

болон оршин сууж буй хүмүүст тулгардаг асуудал, Австралийн өдөр тутмын амьдралын хэв маягтай холбоотой үйл явдлуудын цогц мэдээллийг хүргэгдгээрээ давуу талтай юм байна. **SBS Радиогийн Аудио болон Гадаад Хэлний Контент хариуцсан захирал Манди Викс (Mandi Wicks):** “Хүмүүс англиас бусад хэлээр мэдээлэл авах нэн хэрэгцээтэй байна. Бид үйлчилгээгээ улам тэлж байгаадаа маш их баяртай байгаа. Манай нэвтрүүлгийг үзэгч, сонсогчид дижитал платформоор хүлээн авах нь ихэссэн тул бид контентыг хэрэгцээтэй үедээ, хүссэн цагтаа хүлээн авах боломжтой цахим хэлбэрээр хүргэж байна. Энэ нь залуу үзэгч, сонсогчдод хүрэх хамгийн үр дүнтэй арга гэж бодож байна”⁴ гэж онцлон тэмдэглэсэн байна. Австралийн SBS радиогийн монгол хэл дээрх хөтөлбөрийг Батцогийн Долгион (Danny Battsog) бэлтгэн, сонсогчдод хүргэдэг. Бүх контент нь дижитал буюу хэзээ ч, хаанаас ч сонсох боломжтой подкаст хэлбэрээр sbs.com.au/mongolian болон SBS Радио апп дээр нээлттэй байгаа тул SBS Радио апп-г iTunes App Store болон Google Play дээрээс хэзээд үнэгүй татаж аваад, хаана ч явсан мэдээлэл хүлээн авах боломжтой.

Интернет радио аажмаар бие даасан даяар сүлжээний нэгэн бүрэлдэхүүн болж дөрвөн хэлбэр хүрээнд томъёолохуйц тогтолцоо болов.

Эхний сонголт нь сүлжээний орчинд нэвтрүүлгээ цацдаг энгийн долгионы радио юм. Өөрөөр хэлбэл уламжлалт аналог радио шинэ боломж орчинд нэвтрүүлгээ олон нийтэд хүргэж байгаа хэрэг.

Хоёр дахь хэлбэр нь Зөвхөн интернет хэрэглэгчдэд зориулсан сүлжээний радио болно. Ийм радио нь

тоон технологи эргэх холбоо, хэрэглэгчийн бие даасан сонголтод тулгуурлан хөтөлбөрөө тодорхойлдог.

Гурав дахь хэлбэр нь Last.fm үйлчилгээ буюу богино долгионы дараах үеийн радио бөгөөд хэрэглэгчдийнхээ сонголт, хүсэлтэд үндэслэн бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Энэхүү систем технологи нь (аудио скроблинг) сонсогч нэг бүрийн хэрэглээнд үйлчилэн хөгжим нэвтрүүлгээ хүргэх боломжийг бий болгосон ба сонсох төдийгүй “унших үзэх” мэдээллийг нэгтгэдэг онцлог

Дөрөв дэх хэлбэр нь интернет сүлжээгээр аудио файл (подкастинг) дамжуулдаг үйлчилгээ болой. Интернет хэрэглэгч хэн боловч хүссэн аудио файлаа сүлжээнд чөлөөтэй байршуулж бусад нь түүнийг RSS технологиор дамжуулан хүлээн авдгаараа энэхүү үйлчилгээ түгээмэл болсон⁵.

Монгол улсад 2007 оноос радио телевизийн эфирийг интернетээр шууд дамжуулах технологи нэвтэрч, 2008 оноос гар утсаар телевизийн нэвтрүүлэг үзэх болсон нь интернетийн нэр хүндэд асар их нөлөөлөх болсон юм. Шууд эфир дамжуулах технологи нэвтэрсэн нь радио нэвтрүүлгийг өөрийн вэб болон томоохон портал сайтаар дамжуулан шууд үзэх боломж олгож энэ нь интернет радио сэтгүүл зүйн хөгжилд ихээхэн түлхэц өгсөн юм. Мөн 3.5G технологийг оруулж ирснээр хөдөлгөөнт интернетийн үйлчилгээ улам өргөжих боломж авчирлаа.

Конвергенц нь технологийн хөгжлийн үр дүнд орчин үеийн ОНХМ-үүдийн хоорондох уламжлалт ялгаа арилах болсонтой холбоотой үйл явц юм. Энэ нь юуны түрүүнд технологийн нэгдэн нийлэх үйл явцтай холбоотой бөгөөд компьютерын компани, холбооны сүлжээ, кабелийн

телевиз, сансрын хиймэл дагуул бүгдээрээ шинэ зах зээл, арилжааны орчинд аль болох бага эрсдэлтэй байхын тулд нэгдэн нийлэх эсвэл өрсөлдөх гэсэн хоёр арга замтай тулгарч байна. Үүнд интернет нь шинэ хэрэгслийн тогтолцооны гол суваг зам болж байгаа тул төвлөрлийн үзэгдэл олон нийтийн мэдээллийн харилцааг үндсээр нь өөрчлөх гол хүчин зүйл болжээ. Янз бүрийн мэдээллийн хэрэгслүүд нэгдэн нийлж ойртон нягтарч байгааг бид интернет сонин, компакт дискэн дэх Британика нэвтэрхий толь, гар утсаар дамжуулан телевиз үзэх зэрэг орчин үеийн олон хэрэглээнээс харж болно. Иймд төвлөрлийг ОНМХ-үүдийн хоорондох ялгааг эрс багасгах, хүлээн авагчдын бүтэц болон шинж чанар дахь өөрчлөлтөөс үүдсэн олон нийтийн мэдээллийн даяаршил хэмээх үйл явц ч гэж үздэг ажээ. Өнөөдөр нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн конвергенцийн үйл явц практик дээр жирийн иргэдээс зардал мөнгө ба дадал чадвар, төр засаг болон улстөрийн холбоодоос нөөц боломж, улс төрийн эр зориг шаардах болсон⁶. МҮОНР нь 2017 оны есдүгээр сарын 1 буюу үүсэн байгуулагдсан 84 жилийн ойгоороо фэйсбүүк сүлжээг ашиглан өргөн нэвтрүүлгээ шууд (live) туршилтаар цацсан билээ. Одоо энэ үйл явц улам төгөлдөржин эх орондоо төдийгүй дэлхийн монгол хэлтэй сонсогч үзэгчид олонд хүрэхээс гадна Монголын дуу хоолой радио англи хэлээрх нийтлэл нэвтрүүлгээ мөн фэйсбүүкээр цацаж эхэлсэн юм. Монголын радио өөрийн хөгжлийн явцад сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийг радиогийн сонсохуйн онцлогтой уялдуулж зөвхөн вербалиар (үгээр, дуу авиа, хөгжмөөр) сонсогчдод хүрч байсан бол визуаль (харах) буюу

сошиал медиа коммуникацийн виртуал (одоо энд) гэсэн хамаарал үүсэж орон зай, цацалтын долгион харгалзахгүй үзэгч сонсогчиддоо хүрч интерактив давуу тал ажиглагдах болсон нь сайшаалтай. Энэ ололтоо улам бататгавал “Орчин үед нийтийн харилцааг илүү өргөн илэрхийлж буй хэрэгсэл нь радио өргөн нэвтрүүлэг юм. Интернетийн тусламжтайгаар радиог хамгийн алс холын оронд ч чөлөөтэй сонсож болох бөгөөд харин сансрын холбоо, тоон үзүүлэлтийн формат нь дэлхийн ямар ч өнцөг буланд радиостанц байгуулж ажиллуулах ихээхэн үр нөлөөтэй бизнес болгож байна” хэмээн сэтгүүл зүйн нэрт судлаач, доктор, профессор Я.Н.Засурскийн тэмдэглэсэнчлэн технологийн хүчин зүйл радиогийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх болно.

Ишлэл

- ¹ Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ., х 56.
- ² Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ., х.127
- ³ МХХ. 2017. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. УБ., 8х.
- ⁴ Австралийн SBS радио монгол хэлээр хөтөлбөрүүд нэв втрүүлж эхэлжээ. <http://www.ub.life/p/14667>
- ⁵ [Засурский Я. Н. 2005. Самый открытый источник информации // Теле-радиоэфир : история и современность. М., с. 146.](#)
- ⁶ Зулькафиль М. 2011. Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд. УБ. х.127

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ. Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.
2. Зулькафиль М.
3. Засурский Я. Н. 2005. Самый открытый источник информации // Теле-

радиоэфир: история и современность.
М.

4. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр.
2017. УБ.
5. <http://www.ub.life>

Резюме

В статье автор констатирует, что благодаря Интернету радио приобрело

новый канал доставки информации аудитории. В настоящее время более десяти радиостанций Монголии транслируют свои программы через всемирные сети. А также, некоторые иностранные радиостанции, вещающие на монгольском языке активно используют кибер пространство с целью увеличить количество слушателей.